



**НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСАГ, ӨРХИЙН
АМЬЖИРГААНЫ ТҮҮВЭР СУДАЛГАА**

ССГ-ын Судалгааны хэлтэс³⁶

2016 оны 6 дугаар сар

³⁶ Энэ судалгаанд дурдагдсан аливаа дүгнэлт, дэвшүүлсэн санал нь зөвхөн судлаачийн хувийн байр суурийг илэрхийлэх бөгөөд Монголбанкны байр суурийг илэрхийлэх албагүй болно.

I. ОРШИЛ

Монголбанкны Судалгаа, статистикийн газраас Монгол улсын нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал, банк санхүүгийн байгууллагын хөгжлийн талаар 2016 оны 4 дүгээр сард олон нийтийн дунд 10 дахь жилдээ санал асуулга явууллаа.

Сүүлийн гурван жилийн судалгааны ажлын онцлог нь Засгийн газар, Монголбанктай хамтран хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөртэй холбогдох асуулгыг нэмж оруулсан болно. Өмнөх судалгаануудын суурьд тулгуурлан гол асуултууд дээр иргэдийн санал бодол хэрхэн өөрчлөгдсөнийг динамик хэлбэрээр харуулан чиглэлийн индексийг тооцон үзүүллээ.

1.1. Судалгааны ажлын зорилго

Судалгааны ажлын зорилго нь Монгол улсын нийгэм, эдийн засаг, өрхийн амьжиргааны өнөөгийн байдал, банк санхүүгийн салбарын хөгжлийн талаар иргэдийн дунд санал асуулга явуулан, олон нийтийн санал бодлыг тодорхойлж, өнгөрсөн онуудтай харьцуулан дүн шинжилгээ хийхэд оршино.

1.2. Судалгааны хамрах хүрээ, хугацаа

Санал асуулгыг Улаанбаатар хотын бүх дүүргүүд (Багануур хот, Налайх хотыг оруулаад) болон 21 аймгуудыг хамруулан 2016 оны 4 дүгээр сарын 22-ноос 5 дугаар сарын 2-ны өдөр хүртэлх хугацаанд Монголбанк, судалгаа шинжилгээний “МЭК” ХХК-тай хамтран явууллаа.

1.3. Түүвэрлэлт хийх арга зүй

Эх олонлогийг тодорхойлохдоо нийслэл хот болон аймгуудын эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд үндэслэсэн.

Хүснэгт 1.1. Түүвэрлэлт хийх аргазүй (Санамсаргүй түүвэрлэлтийн арга)

$$p = \frac{Z^2 * r(1 - r) * Pop}{(Pop - 1) * E^2 + Z^2 * r(1 - r)}$$

Түүврийн хэмжээ: $p=4,129$

Тэмдэглэгээ	Утга	Тайлбар
Pop	1 164 060	Эх олонлог буюу нийт эдийн засгийн идэвхитэй хүн ам
Z	2,575	99%-н итгэх магадлалын түвшин
r	0.5	Тогтмол утга
E	0.02	Алдааны хязгаар

Эх олонлогийг тодорхойлохдоо Улаанбаатар хот болон аймгуудын эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд үндэслэсэн.


Улаанбаатар хот ба аймгуудын эдийн засгийн идэвхтэй хүн амын тоог улсын нийт идэвхтэй хүн амын тоонд харьцуулж, хувийн жин, газар зүйн байршлыг харгалзан нийслэл хот болон аймаг тус бүрээс авах оновчтой түүврийн хэмжээг тооцсон.

Энэ удаагийн судалгаанд санамсаргүй түүвэрлэлтийн аргаар нийт 4,767 түүвэр авсан нь дээрх аргачлалын дагуу эх олонлогоос тооцсон оновчтой түүврийн хэмжээ болох 4,129 түүврийг хангаж байна.

1.4. Түүвэрлэлт

Энэ удаагийн санал асуулгад нийт 4,767 иргэд оролцлоо. Судалгаанд хамрагдсан иргэдийн 27.6% буюу 1,315 нь Улаанбаатар хотын (9 дүүрэг) оршин суугчид бол үлдсэн 3,452 буюу 72.4%-ийг орон нутгийн (21 аймаг) иргэд эзэлж байна.

Зураг 1.1 Санал асуулгад оролцсон иргэдийн харьяалал (бүс нутгаар)




Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Орон нутгийн иргэдийг бүс нутгаар авч үзвэл нийт судалгаанд оролцогчдын 18% нь Баруун бүс буюу Говь-Алтай, Баян-Өлгий,

Увс, Ховд, Завхан аймгуудаас, 23% нь Хангайн бүсийн Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Баянхонгор, Булган, Орхон аймгуудаас, 21% нь Төвийн бүс буюу Дархан, Сэлэнгэ, Төв, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр аймгуудаас хамрагдсан бол үлдсэн 10% нь Зүүн бүс болох Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудын иргэд байна.

Эдийн засгийн идэвхтэй хүн амын тооноос хамаарч Говьсүмбэр аймаг, Багануур, Налайх хотоос хамгийн бага буюу тус бүр 50 түүвэр сонгогдсон бол бусад 6 дүүрэг, Хөвсгөл, Баян-Өлгий, Архангай, Өвөрхангай, Сэлэнгэ, Увс зэрэг аймгуудаас хамгийн их буюу тус бүр 200-с дээш түүвэр хамрагдлаа.

Зураг 1.2 Санал асуулгын түүвэрлэлт




Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

II. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд оролцсон иргэдийн 60% нь эмэгтэй, 40% нь эрэгтэй бөгөөд насны байдлаар нь авч үзвэл 12% нь 18-25, 37% нь 26-35, 24% нь 36-45, 18% нь 46-55, 9% нь 56-с дээш гэсэн насны ангилалд хамрагдаж байна (Зураг 2.1).

Зураг 2.1 Санал асуулгад оролцсон иргэдийн мэдээлэл






Эх сурвалж: Монголбанк, НЭЗБС-ийн түүвэр судалгаа

Боловсролын түвшингээр ангилбал 59% нь дээд, 30% нь бүрэн дунд, 4% нь техник мэргэжлийн сургууль (үйлдвэрлэлийн төв), 6% нь бүрэн бус дунд боловсролтой иргэд байв.

Судалгаанд оролцсон иргэдийн 31% нь хувийн, 26% нь төрийн албанд ажилладаг, 19% нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 13% нь ажилгүй байгаа бол бусад нь төрийн бус байгууллага болон гадаадын байгууллагад ажилладаг, цагийн ажил хийдэг иргэд байна.

Энэ удаагийн судалгаанд 26-45 насны, дээд боловсролтой, төрийн болон хувийн байгууллагад ажилладаг, мөн хувиараа хөдөлмөр эрхэлдэг эмэгтэй иргэд түлхүү оролцож санал бодлоо тусгасан байна.

Зураг 2.2 Санал асуулгад оролцсон иргэдийн өрхийн гишүүний тоо




Эх сурвалж: Монголбанк НЭЗБС-ийн түүвэр судалгаа

Судалгаанд хамрагдсан иргэдийн 91% нь өрхөд 1-2 хүн хөдөлмөр эрхэлж, орлого олдог гэж хариулжээ.

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь 3-4 ам бүлтэй өрх байгаа бөгөөд 5-аас дээш ам бүлтэй өрхүүдийн (23.7%) хувьд 1-2 хүн ажил эрхэлж буй үед өрхийн орлогын дарамт үүсэх магадлалтай юм.

Судалгаанд оролцсон иргэдийн өрхийн орлогыг асуухад 54% нь 700 мянган төгрөгөөс доогуур орлоготой байна. Мөн өрхийн орлогын тархалт нь ҮСХ-аас 2016 оны 1-р улиралд явуулсан судалгааны үр дүнтэй ойролцоо байна.


Зураг 2.3 Санал асуулгад оролцсон иргэдийн сарын орлогын тархалт



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Өрхийн дундаж орлогыг аймаг, нийслэлээр нь авч үзвэл Орхон, Дорноговь, Ховд, Дархан-Уул аймгууд хамгийн өндөр орлоготой байгаа бол Говьсүмбэр, Төв, Өвөрхангай, Дорнод аймгууд хамгийн бага орлоготой гэж хариулсан ба Улаанбаатарын иргэд улсын дунджаас доогуур орлоготой харагдаж байна.

Зураг 2.4 Санал асуулгад оролцсон иргэдийн орлогын тархалт (аймаг, нийслэлээр)




Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

III. ӨРХИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА

3.1. Өрхийн амьжиргааны байдал

Санал асуулгын дүнгээр улсын хэмжээнд судалгаанд оролцогчдын 12% нь өрхийн амьжиргааны түвшин дээшилсэн, 49% нь хэвэндээ гэсэн бол 38% нь буурсан гэж хариулжээ.


Зураг 3.1 Танай өрхийн амьжиргааны байдал сүүлийн жилд хэрхэн өөрчлөгдсөн бэ?



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Улаанбаатар хотын иргэдийн хувьд өрхийн амьжиргаа доошилсон гэсэн хариулт орон нутагтай харьцуулахад 14%-иар өндөр байна. Эдийн засгийн өсөлт саарсан тэр дундаа барилга, худалдаа, үйлчилгээний салбарууд бууралттай үед эдийн засгийн хүндрэлийн нөлөө хүн ам ихээр суурьшсан нийслэл хот дахь иргэдийн амьжиргаанд хөдөө орон нутагтай харьцуулахад илүүтэйгээр мэдрэгдсэн байх талтай юм.

Зураг 3.2 Иргэдийн бодит орлого, чиглэлийн индекс (-1-ээс 0 муудсан, 0-д хэвэндээ, 0-ээс 1-д сайжирсан)



Эх сурвалж: Монголбанк НЭЭС-ийн түүвэр судалгаа

Энэ удаагийн судалгаагаар өрхийн амьжиргааны түвшний чиглэлийн индекс 2015 оны түвшнээс огцом буурч 2009 оны хямралын үеийнхээс ч бага түвшинд буюу судалгаа явуулсан нийт хугацааны хамгийн доод утгад хүрчээ.

Иргэд өрхийн амьжиргаа нь 2015 оноос огцом муудсан гэж үзэхэд эдийн засгийн өсөлт саарсан, бизнесийн үйл ажиллагаа хумигдаж ажилгүйдэл нэмэгдсэн, иргэдийн бодит цалин дорвитой нэмэгдээгүй зэрэг нь нөлөөлсөн байна.

Зураг 3.3 Өрхийн амьжиргааны байдал, ажил эрхлэлтээр (-1-ээс 0 муудсан, 0-д хэвэндээ, 0-ээс 1-д сайжирсан)



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Санал асуулгад оролцсон иргэдийн ихэнх нь амьжиргааны байдал хэвэндээ болон доошилсон гэдэг хариултыг өгсөн бөгөөд ажил эрхлэлтээр нь авч үзвэл ажилгүй, цагийн ажил эрхэлдэг, тэтгэвэрт гарсан иргэд илүү их муудсан гэж хариулжээ.

Зураг 3.4 Өрхийн амьжиргааны байдал, ажил эрхэлж буй салбараар (-1-ээс 0 муудсан, 0-д хэвэндээ, 0-ээс 1-д сайжирсан)



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Харин хувийн байгууллага болон төрийн байгууллагад ажилладаг тогтмол цалин, орлоготой иргэдийн хувьд өрхийн амьжиргааны байдал бага зэрэг муудсан гэжээ. Амьжиргааны байдлыг ажил эрхэлж буй салбараар нь авч үзвэл үйлчилгээ, барилга, худалдааны салбарт ажил эрхэлдэг иргэд илүү муудсан гэж хариулсан байгаа бол аялал жуулчлал, хөдөө аж ахуй, банк санхүүгийн салбарынхны амьжиргааны түвшин харьцангуй бага буурсан байна.

3.2. Өрхийн орлого

Судалгаанд оролцсон иргэдийг орлогын гол эх үүсвэрээр нь ангилбал 60% нь цалин, 16% нь бизнесийн орлого, 10% нь тэтгэвэр, тэтгэмжээр голлох орлогоо бүрдүүлж байна.


Зураг 3.5 Танай өрхийн орлогын гол эх үүсвэр юу?



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Үлдсэн 13% нь МAA, газар тариалангийн орлого, цагийн ажлын хөлс, түрээсийн орлого, хүүний орлого болон бусад орлого байна.


Шигтгээ 1. Төлөөлүүлсэн нэг өрхийн сарын дундаж орлого



Өрхийн сарын дундаж орлого 2016 оны I улирлын байдлаар 892.4 мянган төгрөг байна. Өрхийн нийт орлогын дийлэнх буюу 54%-ийг цалингийн орлого, 19%-ийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого бүрдүүлж байгаа бол үлдсэн 27%-ийг МАН, газар тариалангийн орлого болон бусад орлого бүрдүүлж байна.

Судалгаагаар өрхүүдийн 12%-ийн орлого нэмэгдсэн гэсэн бол 46% нь хэвэндээ, 42% нь муудсан гэж хариулсан байна.


Зураг 3.6 Танай өрхийн орлого өнгөрсөн онтой харьцуулахад өөрчлөгдсөн үү?



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Судалгаагаар өрхүүдийн 12%-ийн орлого нэмэгдсэн байгаа бол 46% нь хэвэндээ, 42% нь муудсан гэж хариулсан байна. Харин зардлын хувьд 48% нь өссөн, 29% нь хэвэндээ, 23% нь буурсан гэж хариулжээ.

Зураг 3.7 Өрхийн орлогын өөрчлөлт (Аймгуудаар)
(-1-ээс 0 буурсан, 0-д хэвэндээ, 0-ээс 1-д өссөн)




Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Өрхийн орлого өнгөрсөн онтой харьцуулахад Улаанбаатарт хамгийн их буурсан бол Дорноговь, Сүхбаатар болон Архангай аймагт орлого нэмэгдсэн гэж хариулжээ.

3.3. Өрхийн зарлага

Судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд өрхийн зардал өссөн гэж 48% нь хариулсан бол хэвэндээ гэж 29%, буурсан гэж 23% нь хариулжээ.


Зураг 3.8 Танай өрхийн зарлага өнгөрсөн онтой харьцуулахад өөрчлөгдсөн үү?



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Улаанбаатар хотын иргэдийн хувьд өрхийн зардал өнгөрсөн онтой харьцуулахад хэвэндээ гэсэн хариулт орон нутгийн иргэдтэй ижилхэн байна. Харин нийт иргэдийн хувьд өрхийн зарлага өнгөрсөн онтой харьцуулахад нэмэгдсэн гэж үзжээ.

Зураг 3.9 Өрхийн зардлын өөрчлөлт (Аймгуудаар)
(-1-ээс 0 буурсан, 0-д хэвэндээ, 0-ээс 1-д өссөн)



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Өрхийн зарлага өнгөрсөн онтой харьцуулахад Сүхбаатар, Дорноговь, Баянхонгор аймгуудад зарлага нэмэгдсэн гэж хариулсан бол Улаанбаатар, Төв болон Говьсүмбэр аймгийн иргэд зардал өнгөрсөн онтой харьцуулахад буурсан гэж үзсэн байна.

Зураг 3.10 Аль зардал хамгийн их хувийг эзэлдэг вэ?




Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Судалгааны үр дүнгээр өрхийн зардалд хүнс ба цахилгаан, ус дулааны төлбөр хамгийн их хувь эзэлж байгаа ба дээрх зардлуудын хувь өмнөх оны судалгааны дүнгээс даруй 4-5 нэгж хувиар нэмэгдсэн дүнтэй байна.

Шигтгээ 2: Хэрэглээний барааны үнийн өсөлт

Хэрэглээний үнийн индексийн жилийн өсөлт 2016 оны I улирлын байдлаар 1.1%-тай байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 8.2 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.



Эх сурвалж: УСХ


Хэрэглээний үнийн индексийн жилийн өсөлтийн задаргааг авч үзвэл боловсролын үйлчилгээ 2015 оны I улирлаас хамгийн их өсөлттэй буюу нийт инфляцид 1.7 нэгж хувийг, бол гэр ахуйн бараа хувцас, гутал 0.3 нэгж хувь, цахилгаан халаалт 0.2 нэгж хувь, эмнэлгийн үйлчилгээ, эм тариа 0.2 нэгж хувиар тус тус нэмэгдүүлжээ. Харин хүнсний барааны индекс инфляцийг -0.9 нэгж хувиар бууруулсан бол бусад бараа, бүтээгдэхүүнүүдийн индекс -0.5-иар бууруулсан байна.

Өрхийн бодит орлого сүүлийн 4 улирал дараалан буурч байгаагаас зайлшгүй бус хэрэглээ хумигдан хүнс, цахилгаан ус дулааны төлбөрийн өрхийн зардалд эзлэх хувь нэмэгдсэн байна. Үүний сацуу цахилгаан, ус дулааны үнэ өнгөрсөн оноос бага зэрэг өссөн нь нийт зардалд эзлэх хувь өнгөрсөн судалгаанаас нэмэгдэхэд нөлөөлжээ.

3.4. Өрхийн орлогын хүрэлцээ

Улсын хэмжээнд санал асуулгад оролцсон иргэдийн 6% нь орлого амьжиргаанд хангалттай хүрэлцдэг, 36% нь боломжийн гэсэн бол иргэдийн талаас илүү хувь буюу 58% нь хүрэлцдэггүй гэсэн хариултыг өгчээ.

Зураг 3.11 Таны орлого (цалин, тэтгэвэр, тэтгэмж, бизнесийн...) амьжиргаанд тань хүрэлцдэг үү?




Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Улаанбаатар хотын иргэдийн хувьд орлого хүрэлцдэггүй гэсэн хариулт хөдөө орон нутагтай харьцуулахад бага зэрэг өндөр байгаа нь Улаанбаатар хотын иргэдийн хэрэглээ хөдөө орон нутагтай харьцуулахад өндөр, түүнчлэн ипотекийн зээлд хамрагдагсдын дийлэнх нь Улаанбаатар хотын иргэд байгаатай холбоотой байж болох юм.

Шигтгээ 3. Өрхийн орлого, зарлага

2016 оны I улирлын байдлаар өрхийн сарын дундаж орлого өмнөх оны мөн үеэс 10.9%-иар буурч 936 мянган төгрөг байгаа бол сарын дундаж зарлага 1.9%-иар буурч 1051.1 мянган төгрөгт болжээ.




Эх сурвалж: ҮСХ

Өрхийн бодит орлогын бууралт бодит зардлын бууралтаас 9%-иар өндөр байгаа нь иргэдийн орлогын хүрэлцээ муудсаныг харуулж байна.

Өрхийн орлого, зарлагын зөрүү буюу орлогын хүрэлцээг авч үзвэл 2015 оны эцсийн байдлаар өрхийн сарын дундаж зарлага нь сарын дундаж орлогоос давсан нь иргэд орлогын хүрэлцээ муу байна гэж үзэхэд нөлөөлжээ.

Зураг 3.12 Өрхийн зардлын өөрчлөлт (Аймгуудаар)
(-1-ээс 0 буурсан, 0-д хэвэндээ, 0-ээс 1-д өссөн)



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Орлогын хүрэлцээг аймаг тус бүрээр авч үзвэл Төв, Булган, Баянхонгор аймгуудийн иргэдийн хувьд орлого хүрэлцээ хамгийн муу гэж хариулсан бол Увс, Дорноговь, Архангай, Орхон болон Говьсүмбэр аймгуудын иргэд орлогын хүрэлцээндээ бага зэрэг муу гэсэн үнэлгээг өгчээ.

3.5. Өрхийн зээл

Улсын хэмжээнд судалгаанд оролцогчдын 41% нь орлогоос давсан зардлаа банкнаас зээл авч санхүүжүүлдэг бол 28% нь хувь хүн, найз нөхөд, хамаатан садангаасаа зээлдэг, 16% нь ломбарднаас, 4% нь ББСБ-уудаас зээлдэг гэж хариулжээ.

Зураг 3.13 Орлогоос давсан зардлаа ямар эх үүсвэрээр санхүүжүүлдэг вэ?




Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Үүнээс харахад иргэдийн 61 орчим хувь нь орлогоос давсан зардал, хэрэглээгээ банк, ББСБ, ломбарднаас зээл авах замаар санхүүжүүлж байна. Түүнчлэн 28 орчим хувь нь бусдаас зээлэх байдлаар богино хугацааны хэрэглээгээ хангадаг байна.

Шигтгээ 4. Иргэдийн зээлийн мэдээ

Иргэдийн зээлийн үлдэгдэл 2016 оны I улирлын байдлаар 2,885 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд нийт зээлийн 25 орчим хувьд хүрч, сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай болжээ.


Иргэдийн зээл



Эх сурвалж: Монголбанк

Банкнаас зээлтэй иргэдийн тоог авч үзвэл 2016 оны I улирлын байдлаар давхардсан тоогоор нийт 988 мянган иргэн байна. Үүний 63% нь цалин, тэтгэвэр, ахуйн хэрэглээний зээлтэй иргэд байгаа бол бизнесийн болон бусад (карт, хадгаламж барьцаалсан зээл) зээлтэй иргэд 28%-ийг тус тус эзэлж байна. Харин ипотекийн зээлтэй иргэдийн тоо нийт зээлтэй иргэдийн 8 орчим хувийг бүрдүүлжээ.

Зээлдэгчдийн тоо



Эх сурвалж: Монголбанк

Иргэдийн зээлийн хүү

Иргэдэд олгосон зээлийн дундаж хүү 19.3 хувь байгаа бөгөөд үүнээс ипотекийн зээлийн хүү хамгийн бага буюу 9.1%, тэтгэврийн зээлийн хүү 18.5%-тай байгаа бол цалин болон хэрэглээний зээлийн хүү нийт дунджаас бага зэрэг өндөр буюу 20.5%, 21.1%-тай байна.


Зээлийн төрөл	Зээлийн дундаж хүү (%)	Зээлийн дундаж хугацаа (сар)
Иргэдийн зээл (дундаж)	19.3%	39.0
Ипотекийн зээл	9.1%	187.6 (16.8 жил)
Тэтгэврийн	18.0%	10.1
Цалингийн зээл	20.5%	33.2 (2.8 жил)
Хэрэглээний зээл	21.1%	16.0
Бусад зээл	21.4%	11.0

Эх сурвалж: Монголбанк

Олгосон зээл, хугацааны ангиллаар

Харин иргэдэд олгогдсон зээлийн дундаж хугацааны хувьд орон сууцны ипотекийн зээл 187.6 сар (16.8 жил) цалингийн зээл харьцангуй урт буюу 33.2 сар (2.8 жил) байгаа бол тэтгэврийн зээл хамгийн богино (10.1 сар) байна.

Тайлант улиралд олгосон зээлийн 43.1 хувийг 1 жил хүртэлх хугацаатай, 45.6 хувийг 1-5 жилийн хугацаатай, 11.2 хувийг 5 жилээс дээш хугацаатай олгосон бөгөөд, 1 жил хүртэл хугацаатай зээлийн хувийн жин өмнөх оны мөн үеэс 9.5 нэгж хувиар, 1-5 хүртэл жилийн хугацаатай зээл 0.6 нэгж хувиар тус тус нэмэгдсэн бол 5-аас дээш жилийн хугацаатай зээлийн хувийн жин 2.7 нэгж хувиар буурсан байна.



Эх сурвалж: Монголбанк

Хэрэглээний зээлийн нийт зээлд эзлэх хувь нэмэгдсэн, түүн дотроо цалин, тэтгэвэр, ахуй хэрэглээний зээл 78 орчим хувийг эзэлж байгаа нь иргэдийн ихэнх нь банк, санхүүгийн байгууллагаас зээл авч хэрэглээндээ зарцуулдагийг харуулж байна.


Зураг 3.14 Танай өрх дараах зээлүүдээс алийг нь авч байсан бэ?



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Судалгаанд хамрагдсан иргэдээс ямар нэг зээл авч байсан эсэхийг асуухад судалгаанд оролцогчдын ихэнх буюу 42% нь цалингийн зээл, 13% нь бизнесийн зээл, 12% нь ахуйн хэрэглээний зээл, 12% нь тэтгэврийн зээл байгаа бол ипотекийн зээлд хамрагдсан иргэд 10%-ийг эзэлж байна. Харин малчны зээл авсан иргэд харьцангуй цөөн буюу судалгаанд оролцогчдын 5%-ийг эзэлж байна. Түүнчлэн иргэдийн 66% буюу 2/3 нь хэрэглээний зээлтэй буюу зээл авч хэрэглээндээ зарцуулдаг нь түүвэр судалгаагаар харагдаж байна.

Зураг 3.15 Зээлээ эргэж төлөхөд ямар хүндрэл тулгарч байна вэ?



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Зээлээ эргэн төлөхөд тулгарч буй бэрхшээлүүдээс хамгийн их буюу судалгаанд хамрагдагсдын 30% нь зээлийн хүү өндөр, 14% нь зээлийн хугацаа богино гэж хариулжээ. Зээлийн жигнэсэн дундаж хүү 2016 оны I улирлын байдлаар 19.7%-тай байгаа бол иргэдийн зээлийн хүү тэр дундаа иргэдийн зээлийн дийлэнх хувийг эзэлдэг цалин, хэрэглээ, бизнесийн болон бусад зээлийн хүү 0.8-4.4 нэгж хувь өндөр байгаа нь иргэд зээлийн хүү өндөр гэж үзэхэд нөлөөлжээ.


Банкнаас олгосон зээлийн 90% нь богино (1 жил хүртэлх) буюу дунд (1-5 жил) хугацаатай байгаа нь иргэдийн бизнесийн үйл ажиллагааны циклтэй харьцуулахад богино байна гэж судалгаанд хамрагдсан иргэд үзжээ. Түүнчлэн энэ удаагийн судалгаагаар судалгаанд оролцогчдын

багагүй хувь (12%) нь өрхийн аль нэг гишүүн ажилгүй болох нь хүндрэлтэй гэж хариулсан нь ажилгүйдэл иргэдийн амьжиргаа, орлогод нэлээд хүндрэлтэй асуудал болж байгаа нь харагдаж байна.

3.6. Нийгмийн бусад үйлчилгээ

Судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд эмнэлгийн хүртээмж муу гэж талаас илүү хувь нь буюу 55% нь үзсэн бол 38% нь боломжийн, 7% нь сайн гэж хариулсан байна. Эмнэлгийн хүртээмж муу гэж үзсэн иргэдийн хариултын хувь Улаанбаатар хот болон орон нутагт ойролцоо гарсан байна.


Зураг 3.16 Эмнэлгийн хүртээмж хэр байна вэ?



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Иргэдийн хариултыг аймгуудаар авч үзвэл Дархан-Уул, Хөвсгөл, Баянхонгор, Орхон, Ховд, Сүхбаатар, Төв аймгийн иргэд эмнэлгийн хүртээмж нэлээд муу гэсэн хариултыг өгчээ.


Зураг 3.17 Эмнэлгийн хүртээмж (Аймгуудаар)
(-1-ээс 0 муу, 0-д хэвийн, 0-ээс 1-д сайн)



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Харин Говьсүмбэр, Өвөрхангай, Архангай, Увс, Дорнод, Говь-Алтай, Дорноговь аймгуудын иргэдийн хувьд эмнэлгийн хүртээмж бага зэрэг муу байна гэсэн бөгөөд бусад аймгуудаас харьцангуй боломжийн гэж үзсэн байна.


Зураг 3.18 Эмнэлгийн байгууллагын эмчилгээний чанар хэр байна вэ?



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Түүнчлэн иргэдийн талаас илүү хувь нь буюу 52% нь эмнэлгийн байгууллагуудын эмчилгээний чанар муу байдаг гэж үзсэн бол 39% нь хэвийн, 9% нь сайн гэсэн хариултыг өгчээ.

Зураг 3.19 Эмчилгээний чанар (Аймгуудаар)
(-1-ээс 0 муу, 0-д хэвийн, 0-ээс 1-д сайн)




Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Эмнэлгийн байгууллагын эмчилгээний чанар улсын хэмжээнд ерөнхийдөө муу дүнтэй гарсан бөгөөд Ховд, Орхон болон Дархан-Уул аймгийн иргэд эмчилгээний чанарыг нэлээд муу гэж үзсэн байна. Харин Увс, Өвөрхангай болон Говьсүмбэр аймгийн иргэд бусад аймгуудаас харьцангуй сайн үнэлгээг өгсөн байна.

Улаанбаатар хот болон орон нутгийн иргэдийн дийлэнх хувь нь эмнэлгийн хүртээмж, эмчилгээний чанар муу байдаг гэж хариулжээ. Нарийн мэргэжлийн ур чадвартай эмч, шаардлагатай тоног, төхөөрөмж бүхий голлох томоохон эмнэлгүүд Улаанбаатар хотод төвлөрсөн ч орон нутгийн иргэд Улаанбаатар хотод ирж эмчлүүлдэг нь хот болон орон нутгийн иргэдийн хувьд эмнэлгийн хүртээмж болон чанар муу гэсэн хариулт ойролцоо гарахад нөлөөлсөн байх талтай.

Зураг 3.20 Цэцэрлэг, сургуульд хамрагдалт хэр байна вэ?



Эх сурвалж: Монголбанк НЭЭС-ийн түүвэр судалгаа


Судалгаанд хамрагдсан иргэдийн 19% нь цэцэрлэг сургуульд хамрагдалт сайн, 51% нь боломжийн гэж хариулсан бол үлдсэн 31% нь муу байдаг гэж үзжээ.

Орон нутгаас судалгаанд оролцсон иргэдийн дийлэнх буюу 54% цэцэрлэг, сургуульд хамрагдалт боломжийн байна гэсэн бол Улаанбаатар хотын иргэдийн тал орчим хувь (47%) нь муу гэж үзсэн нь Улаанбаатарт хөдөө орон нутагтай харьцуулахад цэцэрлэг, сургуульд хамрагдалт ихээхэн хүндрэлтэй байгааг харуулж байна.

Шигтгээ 5. Эрүүл мэнд болон боловсролын байгууллагуудын статистик

Монгол улсын эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн эрүүл мэндийн, эмнэлгийн тусламж үйлчилгээний, эм хангамжийн, анагаах ухааны боловсрол, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа хариуцсан төрийн, хувийн хэвшлийн, холимог өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бүрдэнэ.


Эрүүл мэндийн байгууллагын тоо



Эх сурвалж: УСХ

Монгол улсын хэмжээнд 2015 оны байдлаар төрийн болон хувийн хэвшлийн нийт 2,773 эрүүл мэндийн байгууллагууд ажиллаж байна. Үүнээс нийт 576 нь клиникийн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, эмнэлгийн төвүүд, аймаг, дүүрэг, сумдын эмнэлгүүд болон өрхийн эмнэлэг, 1,171 нь хувийн эрүүл мэндийн байгууллагууд байгаа бол 967 нь эмийн сангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд байна.

10,000 хүнд ногдох эмнэлгийн орны тоо




Эх сурвалж: УСХ

Улсын хэмжээнд эмнэлгийн байгууллагын орны тоо 2010 оны хүртэл тасралтгүй бууралттай байсан бол 2011 оноос харьцангуй сайжирч эмнэлгийн хүртээмж нэмэгдэж эхэлжээ. Харин 2012-2014 оны хооронд хүртээмж төдийлөн нэмэгдээгүй байсан бол 2015 онд өмнөх жилүүдээс нэлээд сайжирчээ.

Нэг их эмчид ногдох хүний тоо


Улсын хэмжээнд 2015 оны эцсийн байдлаар нэг их эмчид 310 хүн ногдож байна. Нэг хүнд ногдох их эмчийн тоог аймаг, нийслэлээр авч үзвэл Улаанбаатар, Говьсүмбэр, Дорноговь аймгуудад эмчийн хүрэлцээ бусад аймгуудаас сайн буюу 228, 287, 301 хүн тус тус ногдож байна.

Дийлэнх аймгуудын хувьд улсын дундажтай харьцуулахад эмчийн хүрэлцээ муу байгаа бөгөөд ялангуяа Архангай, Хөвсгөл, Баян-Өлгий аймгуудад хүрэлцээ хамгийн муу буюу нэг их эмчид ногдох хүний тоо Улаанбаатар хотоос даруй хоёр дахин их байна.



Эх сурвалж: УСХ


10,000 хүүхдэд ногдох цэцэрлэгийн тоо



Эх сурвалж: YCX

Цэцэрлэгийн хүрэлцээг орон нутаг болон Улаанбаатар хотын хувьд авч үзвэл 2015 оны эцсийн байдлаар хөдөө орон нутгийн 10,000 хүүхдэд 67 цэцэрлэг ногдож байгаа бол Улаанбаатар хотод түүнээс арай бага буюу 61 орчим цэцэрлэг ногдож байна.

10,000 сурагчид ногдох сургуулийн тоо



Эх сурвалж: YCX


Харин сургуулийн хүрэлцээг авч үзвэл хөдөө орон нутгийн 10,000 сурагчдад 17-18 сургуульд ногдож байгаа бол Улаанбаатар хотод түүнээс ойролцоогоор 2 дахин бага буюу 10 сургууль ногдож байна.

Улаанбаатар хот дахь сургуулийн хүрэлцээ хөдөө орон нутагтай харьцуулахад бага байгаа нь 10,000 сурагчид ногдох сургуулийн тооноос харагдаж байна.

Харин 10,000 хүүхдэд ногдох цэцэрлэгийн тооноос харвал Улаанбаатар хотод сүүлийн жилүүдэд цэцэрлэгийн тоо нэмэгдэх хандлагатай байгаа

ч хөдөө орон нутагтай харьцуулахад цэцэрлэгийн хүрэлцээ муу хэвээр байна.

Зураг 3.21 Цэцэрлэг, сургуульд хамрагдалт (Аймгуудаар)
(-1-ээс 0 муу, 0-д хэвийн, 0-ээс 1-д сайн)



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Эмнэлгийн байгууллагын хүртээмж, эмчилгээний чанартай харьцуулахад цэцэрлэг, сургуульд хамрагдалт улсын хэмжээнд харьцангуй боломжийн дүнтэй гарсан. Тухайлбал Говь-Алтай, Архангай, Завхан аймгуудын иргэд цэцэрлэг, сургуульд хамрагдах байдал сайн гэж хариулсан байна. Харин Дархан-Уул, Улаанбаатар болон Ховд аймгийн иргэд цэцэрлэг, сургуульд хамрагдах байдал бага зэрэг муу гэж хариулжээ.

3.7. Амьжиргааг сайжруулахын тулд авах шаардлагатай арга хэмжээ

Санал асуулгад оролцогчдын ихэнх нь өрхийн амьжиргааг сайжруулахын тулд нэн тэргүүнд ажлын байрыг нэмэгдүүлэх, цалин, тэтгэврийг өсгөх, хэрэглээний барааны үнийн өсөлтийг бага түвшинд байлгах болон эдийн засгийн тогтвортой орчин бий болгох арга хэмжээнүүдийг авах нь зүйтэй гэж үзсэн байна.

Зураг 3.22 Авах шаардлагатай арга хэмжээ



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Үүний дараагаар бизнес эрхлэх орчин, нөхцөлийг сайжруулах, ядуурлыг бууруулах, эмнэлгийн үйлчилгээг чирэгдэлгүй хүртээмжтэй болгох, цэцэрлэг сургуулийн хүрэлцээг нэмэгдүүлэх, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийг төрийн бодлогоор зохицуулах шаардлагатай байна гэжээ.

Өмнөх судалгаагаар цалин тэтгэвэр өсгөх, эдийн засгийн тогтвортой орчинг бий болгох гэсэн сонголтууд нэн тэргүүнд байсан бол энэ удаагийн судалгаагаар ажлын байрыг нэмэгдүүлэхийг харьцангуй их сонгосон байгаа нь ажилгүйдэл нийгмийн ихээхэн тулгамдсан асуудал болж байгааг тодотгон харуулж байна.

3.8. Өрхийн амьжиргааны талаарх түүвэр судалгааны дүгнэлт

Өрхийн амьжиргааны байдал өмнөх судалгааны дүнгээс огцом буурч, 2002 оноос хойших нийт судалгаа явуулсан үеүдийнхээс хамгийн доод түвшиндээ хүрсэн бөгөөд тогтмол орлогогүй, цагийн ажил хийдэг, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, тэтгэвэр авдаг иргэдийн амьжиргаа нэлээд муудсан байна.

Түүнчлэн эдийн засгийн өсөлт саарсан, тэр дундаа ажиллах хүч ихээр шаардагддаг худалдаа, үйлчилгээ, барилгын салбарын өсөлт буурч ажилгүйдэл нэмэгдсэн нь хүн ам ихээр суурьшсан Улаанбаатар хот дахь иргэдийн орлого буурч, амьжиргаа нь муудахад голлон нөлөөлжээ.

Цалингийн, бизнесийн орлого болон тэтгэвэр, тэтгэмж нь өрхийн орлогын гол эх үүсвэр болдог ба сүүлийн жилүүдэд орлого төдийлөн өсөөгүй байна. Харин хүнсний барааны үнэ бууралттай байсан ч хэрэглээ хумигдаагүй, үүний зэрэгцээ зайлшгүй хэрэглээний (цахилгаан, ус, дулаан) зардал бага зэрэг өссөн нь орлогын хүрэлцээг бууруулж, амьжиргаанд сөргөөр нөлөөлж байна.

Иргэд орлогоос давсан зардлаа ихэвчлэн зээлээр тэр дундаа банкнаас хэрэглээний зээл (*цалин, хэрэглээ, тэтгэврийн зээл*) авч санхүүжүүлдэг байна. Уг зээлээ эргүүлэн төлөхөд зээлийн хүү өндөр, хугацаа богино мөн ажилгүйдэл нэмэгдэж байгаатай холбоотойгоор өрхийн аль нэг гишүүн ажилгүй болох нь ихээхэн хүндрэл болдог гэж судалгаанд оролцогчид үзжээ.

Иргэд эмнэлгийн хүртээмж, эмчилгээний чанарт өмнөх жилүүдийн адил хангалтгүй гэсэн үнэлгээг өглөө. Эмч мэргэжилтний тоо хүрэлцээгүй байгаагийн зэрэгцээ эмчийн ур чадварыг дээшлүүлэх, эмнэлгийн тоног, төхөөрөмжийг сайжруулах шаардлагатай байгаа талаар судалгаанд оролцогчид дурдаж байлаа.

Сургууль, цэцэрлэгийн хүртээмж нийслэлд ихээхэн тулгамдсан асуудал болж байгаа ба 10,000 хүүхдэд ногдох сургуулийн тоогоороо хөдөө, орон нутгаас хоёр дахин бага үзүүлэлттэй байна.


Иргэд эдийн засгийн байдал хүндэрсэн, бизнесийн үйл ажиллагаа хумигдаж ажилгүйдэл нэмэгдсэнтэй холбоотойгоор ажлын байрыг хадгалах, цаашлаад шинээр ажлын байрыг бий болгох болон цалин, тэтгэврийг өсгөх нь өрхийн амьжиргааг сайжруулахын тулд нэн тэргүүнд авах шаардлагатай арга хэмжээ гэжээ. Түүнчлэн эдийн засгийн тогтвортой орчинг бий болгох нь иргэдийн амьжиргаанд эерэгээр нөлөөлнө гэж үзсэн байна.

IV. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА

4.1. Гадаад орчны нөлөө

Санал асуулгад оролцсон иргэдийн тал орчим буюу 49% нь эдийн засгийн гадаад орчин манай улсад сөргөөр нөлөөлж байна, 27% нь нөлөөгүй гэж үзсэн бол 25% нь эергээр нөлөөлж байна гэсэн хариултыг өгчээ.

Зураг 4.1 Эдийн засгийн гадаад орчин манай улсад ямар нөлөө үзүүлж байна вэ?



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Манай улсын экспортын 90 гаруй хувийг бүрдүүлдэг уул уурхайн түүхий эдийн дэлхийн зах зээл дэх үнэ 2011 оноос хойш тасралтгүй буурсан нь экспортын орлогыг багасгах гол шалтгаан болсон байна.


Үүний зэрэгцээ богино хугацааны хөрөнгийн гадагшлах урсгал бага зэрэг нэмэгдсэн, ГШХО-ын хэмжээ (эдийн засаг эрчимтэй өсч байсан үетэй харьцуулахад) эрс буурсан нь иргэдийн хувьд гадаад орчин эдийн засагт сөргөөр нөлөөлж байна гэж үзэхэд нөлөөлжээ.

Шигтгээ 6. Гадаад эдийн засгийн орчин

2016 оны I улиралд АНУ, Хятадын эдийн засгийн өсөлт саарсан бол Евро бүсийн эдийн засаг тогтвортой өслөө. Хэрэглээ, хөрөнгө оруулалт өсч, Хятадын эдийн засгийг дэмжсэн ч гадаад эрэлт сул байгаагаас экспорт буурсан нь эдийн засгийн өсөлт саарах гол хүчин зүйл болж байна. Газрын тос, металлуудын үнэ хямдарсанаас хөрөнгө оруулалт, аж үйлдвэрийн салбар дахь нийт үйлдвэрлэл буурч, АНУ-ын эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлэв. Харин газрын тосны хямд үнэ, мөнгөний уламжлалт бус тэлэх бодлогын нөлөөгөөр Евро бүсийн дотоод эрэлт өсч, эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Оросын эдийн засгийн хувьд инфляци буурч, үйлчилгээний салбар идэвхжиж, алгуур сэргэх төлөвтэй байна.

Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ нэмэхээ хойшлуулсанаар ам.долларын ханш суларсаны зэрэгцээ Хятадын барилгын салбар идэвхжиж, нүүрс, төмрийн хүдэр, зэсийн импорт нэмэгдсэн нь 2016 оны 3-4 дүгээр сард голлох металлуудын үнэ өсөхөд нөлөөлжээ. 4 дүгээр сард болсон ОПЕК-ийн ээлжит хурлаар гишүүн орнууд газрын тосны нийлүүлэлтээ царцаах хэлэлцээрт хүрч чадаагүйн дээр Иран улс нийлүүлэлтээ нэмэх бодлогыг хатуу баримталж байгаа нь газрын тосны үнэ хямд байх гол хүчин зүйл болж байна.

Монгол улсын экспортын гол нэрийн барааны дэлхийн зах зээл дээрх үнэ



Зэс: 2016 оны I улиралд дунджаар 4675\$ байсан нэг тонн зэсийн үнэ 4 дүгээр сард 4873\$-г хүрч өслөө. Хятадын барилгын салбар идэвхжиж, зэсийн импорт 2, 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 50, 36 хувиар тус тус өссөн, Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ хэвээр үлдээж, ам.долларын ханш суларсан, түүнчлэн 4 дүгээр сарын дунд үед Чилид их хэмжээний үер болж, зэсийн уурхай 6 өдрийн турш хаагдсанаас үнэ ийнхүү өсчээ.

Алт: 2016 оны I улиралд дунджаар 1181\$ байсан нэг унц алтны 4 дүгээр сард өсч, 1242\$-г хүрчээ. Холбооны Нөөцийн Банк 4 дүгээр сарын хурлаар бодлогын хүүгээ хэвээр үлдээж, ам.долларын ханш суларсанаар алтны ханшийг дэмжлээ. Түүнчлэн, эдийн засгийг дэмжих зорилгоор Япон, Швед, Данийн төв банкууд хасах хүүгийн бодлогод шилжсэн нь хөрөнгө оруулагчид евро, ам.доллараас илүүтэй алтанд хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлж, алтны үнэ ийнхүү өсчээ.

Хүрэн нүүрс: 2016 оны I улиралд дунджаар 40\$ байсан нэг тонн хүрэн нүүрсний үнэ 4 дүгээр сард өсч, 47\$-г хүрчээ. Уул уурхайн салбарт тэргүүлэх компанийн нэг Би Эйч Пи Билитоны хүрэн нүүрсний үйлдвэрлэл 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 24 хувиар буурч, нийлүүлэлт саарсан, Хятадын хүрэн нүүрсний импорт 3 дугаар сард 47 хувиар нэмэгдсэн зэргээс шалтгаалан үнэ ийнхүү өсчээ.

Коксжих нүүрс: 2016 оны I улиралд дунджаар 81\$/тн байсан Австралийн Японтой хийсэн сайн чанарын коксжих нүүрсний гэрээний жишиг үнэ 4 дүгээр сард 84\$/тн-д хүрч өссөн ба үүнийг дагаад Австралийн коксжих нүүрсний захын ханш 4 дүгээр сард өсч, 81\$/тн-д хүрчээ. Коксжих нүүрсний үйлдвэрлэлээр улсдаа дээгүүрт орох Хятадын Шанси мужид олборлолт буурч, коксжих нүүрсний импорт 3 дугаар сард өмнөх сараас 72 хувиар өссөн дүнтэй гарсан нь үнэ өсөхөд голлон нөлөөлжээ.

Түүхий нефть: 2016 оны I улиралд дунджаар 34\$ байсан нэг баррель Brent маркийн газрын тосны үнэ 4 дүгээр сард 41\$-г хүрч өсчээ. Иран газрын тосны зах зээлд эргэн ирсэнээр нийлүүлэлт нэмэгдсэн нь I улиралд үнэ хямд байх гол хүчин зүйл болсон бол 4 дүгээр сард ОПЕК-ийн гишүүн орон болох Кувейт улсад газрын тос олборлогч компаниудын ажилчдын дунд ажил хаялт болж, нийлүүлэлт саарсан нь үнэ өсөхөд нөлөөлжээ.

Монгол улсын төлбөрийн тэнцэл




Эх сурвалж: Монголбанк

2016 оны 1-р улиралд урсгал данс 11 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн данс 141 сая ам.долларын ашигтай, нийт төлбөрийн тэнцэл 38 сая ам.долларын алдагдалтай буюу гадаад валютын улсын нөөц уг дүнгээр буурчээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад урсгал дансны алдагдал 17 сая ам.доллараар буурсан бол хөрөнгө ба санхүүгийн данс 177 сая ам.доллараар сайжирсан байна.

4.2. Эдийн засгийн байдал

Санал асуулгад оролцсон нийт иргэдийн 6% нь эдийн засаг сайжирч байна, 27% нь хэвэндээ байна гэж хариулсан бол **дийлэнх буюу 72% нь эдийн засгийн байдлыг муудаж** байна гэсэн хариултыг өглөө.


Зураг 4.2 Эдийн засгийн өнөөгийн байдал ямар байна вэ?



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Эдийн засгийн өнөөгийн байдал муудаж байна гэсэн хариултын хувь Улаанбаатар хотод харьцангуй өндөр байна. Улаанбаатар хотод голлон төвлөрсөн, ажиллах хүч ихээр шаарддаг барилга болон худалдаа, үйлчилгээний салбаруудын идэвхжил суларсан нь хүн ам ихээр суурьшсан нийслэлийн иргэдийн хувьд ажилгүйдэл нэмэгдэн, өрхийн орлого буурч улмаар эдийн засгийн байдал муудаж байна гэж үзэхэд нөлөөлжээ.

Зураг 4.3 ДНБ-ий өсөлт, чиглэлийн индекс (-1-ээс 0 муудсан, 0-д хэвэндээ, 0-ээс 1-д сайжирсан)




Эх сурвалж: ҮСХ, Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

2011 онд эдийн засгийн өсөлт хамгийн өндөр буюу 17.5 хувьд хүрч байсан бол 2013 оноос эдийн засгийн өсөлт саарч 2015 оны эцэст 2.3%-д хүрсэн байна.

Энэ удаагийн судалгаагаар эдийн засгийн өнөөгийн байдлын талаарх чиглэлийн индекс өмнөх судалгааны дүнгээс бага зэрэг сайжирсан хэдий ч “эдийн засаг муудсан” гэсэн мужид хэвээр байна.

Иргэдийн эдийн засгийн байдалд өгсөн үнэлгээ өмнөх судалгааны дүнгээс бага зэрэг сайжрахад дэд бүтцийн (*төмөр зам, Эгийн голын усан цахилгаан станц*) томоохон төслүүдийн санхүүжилт шийдэгдсэн, түүнчлэн “Оюутолгой”-н гүний уурхайн бүтээн байгуулалт эхэлж, ажиллах хүчний эрэлтээ нэмэгдүүлэхээр байгаа нь нөлөөлсөн байх талтай.

Зураг 4.4 Эдийн засгийн өнөөгийн байдал (Аймгуудаар)
(-1-ээс 0 муу, 0-д хэвийн, 0-ээс 1-д сайн)



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Өмнөговь, Баянхонгор аймаг болон Улаанбаатар, Дундговь аймгийн иргэд эдийн засгийн өнөөгийн байдал нэлээд муудсан гэж үзсэн бол

Говьсүмбэр, Дорнод, Хэнтий аймгийн иргэд харьцангуй бага муудсан гэж хариулсан байна.

Шигтгээ 7. Эдийн засгийн бодит өсөлт

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий бодит өсөлт 2015 онд 2.3% болж, өсөлтийн хурдац нь 2014 оны гүйцэтгэлээс 5.6 нэгж хувиар саарсан үзүүлэлттэй гарлаа.


ДНБ-ий бодит өсөлтөд үзүүлж эдийн засгийн салбаруудын хувь нэмэр



Эх сурвалж: ҮСХ

Эдийн засгийн бодит өсөлтөд хөдөө аж ахуй, уул уурхайн салбарын үзүүлэх хувь нэмэр харьцангуй тогтвортой хадгалагдаж, эерэг нөлөө үзүүлж байгаа бол улсын төсвийн нөлөөлөл буюу бүтээгдэхүүний цэвэр татварын бодит өөрчлөлт 2014 оны 2 дугаар улирлаас эхлэн сөрөг утгатай болж, энэхүү хандлага 2015 оны турш үргэлжилсэн нь ДНБ-ий бодит өсөлтийг бууруулах чиглэлд нөлөөтэй байв.

ДНБ-ий бодит өсөлтийн задаргаа (эцсийн ашиглалтын аргаар)




Эх сурвалж: ҮСХ

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ий задаргаанаас харахад нийт хөрөнгө оруулалт 2014 онд эрс багасч, 2015 онд үргэлжлэн буурч байгаа нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлсөн байна. Харин эцсийн хэрэглээ харьцангуй тогтвортой түвшинд байж, 2009 оны эдийн засгийн хямралын үеийнх шиг агшиж, буураагүй байна. Гадаад худалдааны тэнцэл 2015 онд 531 тэрбум төгрөгийн ашигтай гарснаар цэвэр экспорт ДНБ-ий бодит өсөлтөд голлох эерэг нөлөөг үзүүлсэн.

Санал асуулгад оролцсон иргэдийн 7% нь инфляцийн түвшин бага, 12% нь боломжийн байна гэсэн хариултыг өгсөн бол дийлэнх буюу 81% нь (өмнөх судалгааны дүнгээс 5 нэгж хувиар буурсан) инфляцийн түвшин өндөр байна гэж хариулжээ.


Зураг 4.5 Бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт ямар байна вэ?



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Улаанбаатар хотын иргэдийн хувьд үнийн түвшин өндөр байна гэж үзэх хувь орон нутгийн иргэдтэй харьцуулахад бага зэрэг өндөр байгаа нь хэрэглээ болон түүнтэй холбоотой нэмэлт зардлууд (тээвэр, нийслэлийн татвар гэх мэт) их байдаг нь нөлөөлсөн байх талтай.

Зураг 4.6 Үнийн өсөлт, чиглэлийн индекс
 (-1-ээс 0 буурч байна, 0-д боломжийн, 0-ээс 1-д өсч байна)




Эх сурвалж: YCX, Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Монголбанк, ЗГ-тай хамтран 2012 оны эцсээс “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхэлснээр гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнэ харьцангуй тогтворжсон бөгөөд эдийн засгийн хүндрэлээс үүдэн нийт эрэлт буурснаар инфляцийн түвшин 2016 оны 4 дүгээр сарын байдлаар 2.1% болж буураад байна.

Инфляцийн түвшин буурч байгаа өнөөгийн нөхцөлд иргэдийн дунд **үнийн өсөлтийн түвшин нэмэгдэж байна гэж үзэх хандлага** өмнөх судалгааны дүнгээс **буурч**, 2009 оны хямралын үеийнхтэй ойролцоо түвшинд гарлаа.

Зураг 4.7 Бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт (Аймгуудаар)
 (-1-ээс 0 буурч байна, 0-д боломжийн, 0-ээс 1-д өсч байна)



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Үнийн өсөлтийг өндөр байна гэж улсын хэмжээнд судалгаанд оролцогчид хариулсан ч хамгийн ихээр үнэ өссөн гэж хариулсан нь Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь аймгийн иргэд байгаа бол Баян-Өлгий, Завхан, Архангай аймгуудийн иргэд үнийн өсөлтийг өндөр гэж үзэх хандлага харьцангуй бага байна.

Санал асуулгад оролцсон иргэдийн 14% нь төгрөгийн ханш цаашид сулрах нь дээр гэж үзсэн бол 31% чангарах нь дээр гэсэн хариултыг өглөө. Харин иргэдийн тал гаруй хувь буюу 55% нь төгрөгийн ханш цаашид тогтвортой байх нь дээр гэж үзжээ.

Зураг 4.8 Төгрөгийн өнөөгийн ханш цаашид?



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Улаанбаатар хотын иргэдийн хувьд төгрөгийн ханш сулрах нь дээр гэсэн хариулт орон нутгийн иргэдтэй харьцуулахад бага зэрэг өндөр байна.

Зураг 4.9 Ханшийн жилийн өөрчлөлт: ₮/\$




Эх сурвалж: Монголбанк

Гадаад, дотоод эдийн засгийн тааламжгүй нөхцөл байдлаас шалтгаалан хөрөнгийн дотогшлох урсгал огцом буурч, гарах урсгал бага зэрэг нэмэгдсэн нь 2013 оны сүүл үеэс төгрөгийн ханш огцом сулрах үндсэн шалтгаан болж 2014 онд дунджаар 22.9%-иар төгрөгийн ханш суларсан.

Харин 2015 оны эхнээс төгрөгийн ханшийн сулралтын хурд саарч, 2016 оны 4 дүгээр сарын байдлаар төгрөгийн ханш дунджаар 2.9%-иар суларчээ.

Иргэдийн хувьд төгрөгийн ханшийг өнөөгийн түвшинд тогтвортой бөгөөд бага зэрэг чангарах чиглэлд байхыг илүүд үзсэн байна.

Зураг 4.10 Төгрөгийн өнөөгийн ханш цаашид (Аймгуудаар)
(-1-ээс 0 сулрах нь дээр, 0-д тогтвортой байсан дээр, 0-ээс 1-чангарах нь дээр)




Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Төгрөгийн ханшийн талаар Ховд, Өмнөговь, Баянхонгор аймгийн иргэд бусдаасаа харьцангуй ихээр чангарсан нь дээр гэдэг хариултыг сонгосон бол Говьсүмбэр, Хэнтий, Төв, Дорноговь, Архангай аймаг болон Улаанбаатарын иргэд бусад аймгуудаас илүүтэйгээр төгрөгийн ханшийг өнөөгийнхтэй ойролцоо түвшинд тогтвортой байсан нь дээр гэж үзсэн байна.

Судалгаанд оролцсон иргэдийн дийлэнх буюу 88% нь ажилгүйчүүдийн тоо өссөн гэсэн бол 8% нь хэвэндээ, 4% нь буурсан гэсэн хариултуудыг өгчээ. Улаанбаатар хот болон орон нутагт ажилгүйдлийн түвшин нэмэгдсэн гэх хариултын хувь ойролцоо түвшинд байна.


Зураг 4.11 Ажилгүйдэл ямар байн вэ?



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Энэ удаагийн түүвэр судалгаагаар ажилгүйдлийн чиглэлийн индекс өмнөх судалгааны дүнгээс өсч, судалгаа явуулсан үеүдийнхээс хамгийн өндөр түвшинд хүрлээ.

Зураг 4.12 Ажилгүйдлийн түвшин, чиглэлийн индекс (-1-ээс 0 буурсан, 0-д хэвэндээ, 0-ээс 1-д өссөн)




Эх сурвалж: ҮСХ, Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Хямралын жил болох 2009 онд ажилгүйдлийн түвшин огцом нэмэгдэж байсан бол 2011-2015 онуудын хооронд харьцангуй тогтвортой байсан. Харин 2016 оны I улирлын байдлаар ажилгүйдлийн түвшин оны эхнээс огцом (3.3 нэгж хувиар) нэмэгдэж 11.6%-д хүрсэн байна. Эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан бизнесийн идэвхжил суларч, ААН-ын үйл ажиллагаа хумигдан, улмаар ажилгүйдлийн түвшин нэмэгдсэн нь иргэдийн дунд ажилгүйдэл нэмэгдсэн гэх хандлага өсөхөд нөлөөлжээ.

Ажилгүйдлийн тоо өссөн эсэхийг асуусан асуултанд Дархан-Уул, Дорноговь, Өмнөговь аймгийн иргэд ажилгүйдэл хамгийн ихээр өссөн гэж хариулсан бол Увс, Дорнод, Хэнтий, Төв аймгийн иргэд бусад аймгуудаас харьцангуй бага өссөн гэж гэж хариулжээ.


Зураг 4.13 Ажилгүйдлийн түвшин, (Аймгуудаар)
(-1-ээс 0 буурсан, 0-д хэвэндээ, 0-ээс 1-д өссөн)



Эх сурвалж: Монголбанк НЭЭС-ийн түүвэр судалгаа

Судалгаанд оролцсон иргэдийн 87% нь ядуурал нэмэгдсэн, 8% нь хэвэндээ гэсэн бол үлдсэн 5% нь буурсан гэж хариулжээ. Ядуурлын түвшин нэмэгдсэн гэх хариултын хувь Улаанбаатар хот болон орон нутагт ойролцоо хэмжээнд байна.

Зураг 4.14 Хүн амын ядуурал ямар байна вэ?



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Энэ удаагийн түүвэр судалгаагаар ядуурал нэмэгдсэн гэж үзэх хандлага судалгаа авч эхэлсэн үеүдийнхээс хамгийн дээд цэгтээ хүрсэн нь 2013 оныхоос ойролцоогоор 2 дахин муудсан үзүүлэлттэй байна.


Зураг 4.15 Ядуурлын чиглэлийн индекс (-1-ээс 0 буурсан, 0-д хэвэндээ, 0-ээс 1-д нэмэгдсэн)



Эх сурвалж: УСХ, Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Эдийн засгийн идэвхжил суларсан, бизнесийн үйл ажиллагаа хумигдсан, ажилгүйдлийн түвшин нэмэгдсэн, иргэдийн бодит орлого дорвитой өсөөгүй зэрэг нь иргэдийн дунд ядуурал нэмэгдсэн гэх хандлага өсөхөд нөлөөлсөн байх талтай.

Зураг 4.16 Хүн амын ядуурал (Аймгуудаар)
(-1-ээс 0 буурсан, 0-д хэвэндээ, 0-ээс 1-д нэмэгдсэн)




Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Хүн амын ядуурлын түвшин өссөн гэж Дархан-Уул, Өвөрхангай, Баян-Өлгий, Баянхонгор аймгийн иргэд хамгийн ихээр хариулсан бол Төв, Дорнод, Говьсүмбэр болон Хэнтий аймгийн иргэдийн харьцангуй бага хувь нь ядуурал өссөн гэж хариулжээ.

4.3. Эдийн засгийн ирээдүйн төлөв

Судалгаанд оролцогчдын 26% нь уул уурхайн салбар, 25% нь хөдөө аж ахуйн салбар, 19% нь боловсруулах үйлдвэрлэл **эдийн засгийн хөгжлийг ойрын ирээдүйд тодорхойлох** гол салбар гэж үзсэн байна. Иргэдийн дунд уул уурхай салбарт итгэх итгэл төдийлөн буураагүйн зэрэгцээ ХАА, боловсруулах салбарыг хөгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн хэвээр байна.

Зураг 4.17 Эдийн засгийн хөгжлийг ойрын ирээдүйд ямар салбар тодорхойлох вэ?



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Уул уурхайн салбарт өгсөн иргэдийн хариулт өмнөх судалгааны дүнгээс бага зэрэг өсөхөд дотоодын нийт бүтээгдэхүүн 2016 оны I улиралд өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар өссөн, үүн дотроо уул уурхайн салбарын өсөлт 4% буюу голлох хувь нэмрийг оруулсан нь нөлөөлсөн байх талтай.

Санал асуулгад оролцсон иргэдийн хувьд эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэхийн тулд жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих, боловсруулах үйлдвэрийг байгуулах, ХАА-н үйлдвэрлэл, экспортыг дэмжих, уул уурхайн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх хэрэгтэй гэжээ.

Зураг 4.18 Эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэхийн тулд ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Иргэд ХАА-н салбарын үйлдвэрлэл, экспортыг дэмжиснээр эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэх, урт хугацаан дахь тогтвортой байдлыг хангах, орон нутгийн хөгжлийг дэмжих чухал ач холбогдолтой гэж үзсэн байна.

Түүнчлэн зам тээврийг сайжруулах, газар тариалан хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ аялал жуулчлалыг хөгжүүлэх, нарийн мэргэжлийн, өндөр ур чадвартай боловсон хүчин бэлтгэх нь зүйтэй гэж хариулжээ.


Өмнөх онтой харьцуулахад зам тээврийг сайжруулах гэсэн хариултын хувь буурсан нь сүүлийн жилүүдэд хийгдсэн 21 аймгийг хатуу хучилттай замаар холбох зорилтот ажил, “Гудамж” төсөл хэрэгжсэн

зэрэгтэй холбоотой байх талтай.

4.4. Гадаад өр, зээл

Санал асуулгад оролцсон нийт иргэдийн 57% нь эдийн засгаа хөгжүүлэхийн тулд гадаадаас зээл авах нь буруу гэж үзсэн бол үлдсэн 43% нь зөв гэжээ.

Зураг 4.19 Гадаадаас зээл авч эдийн засгаа хөгжүүлэх нь зөв үү?



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Гадаадаас авсан зээлүүд нь уул уурхайн, дэд бүтцийн томоохон төслүүдээс гадна төсөв болон төлбөрийн тэнцлийг алдагдлыг санхүүжүүлэх, гадаад валютын нөөцийн хомсдолыг бууруулахад зарцуулагдаж буй хэдий ч иргэд эдийн засгийн байдал төдийлөн сайжрахгүй байгаа бөгөөд урт хугацаанд өрийн дарамтад оруулах эрсдэлтэй гэж үзсэн байна.

Шигтгээ 8. Гадаад өрийн статистик

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл тайлант улирлын эцэст 22,599 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 8%-иар буюу 1,614 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнд:

- Засгийн газрын гадаад өр 14%-иар буюу 480 сая ам.доллараар өсч 4,036 сая ам.долларт,
- Төв банкны гадаад өглөг 11%-иар буюу 208 сая ам.доллараар өсч 2,084 сая ам.долларт,
- Банкуудын гадаад өр 30%-иар буюу 481 сая ам.доллараар өсч 2,061 сая ам.долларт,
- Бусад сектор (ААН)-ын гадаад өр 4%-иар буюу 122 сая ам.доллараар өсч 3,568 сая ам.долларт,
- Гадаадын хөрөнгө оруулагчаас авсан зээлийн эх үүсвэр 3%-иар буюу 322 сая ам.доллараар өсч 10,850 сая ам.долларт тус тус хүрсэн байна.




Эх сурвалж: Монголбанк

4.5. Банкны салбарын үйл ажиллагаа, үйлчилгээ

Энэ удаагийн судалгааны дүнгээр 44% нь банк, үлдсэн 56% нь бусад эх үүсвэрээс мөнгөний хэрэгцээ гарсан үед зээл авдаг гэж хариулжээ.

Зураг 4.20 Мөнгөний хэрэгцээ тулгарвал хамгийн түрүүнд ямар байгууллагад ханддаг вэ?




Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Эдийн засгийн хүндрэлтэй байдал, ААН-үүдийн бизнесийн үйл ажиллагаа хумигдсан (бизнесийн эрсдэл) чанаргүй зээлийн хэмжээ өссөн зэргээс шалтгаалан банкууд зээлийн шалгуур, нөхцөлөө чангаруулсан хэвээр байна. Улмаар хувь хүн, ломбард болон банкнаас бусад санхүүгийн байгууллагад ханддаг гэсэн хариултын хувь сүүлийн хоёр жилийн судалгаагаар нэлээд өссөн байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 51% нь банкны салбарын өнөөгийн байдал найдвартай гэж үзсэн бол 29% нь эргэлзээтэй, 19% нь хүндрэлтэй байна гэж хариулжээ.


Зураг 4.21 Банкны салбарын үйл ажиллагаа ямар байна вэ?



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа


Орон нутгийн иргэд Улаанбаатар хотоос илүүтэйгээр банкны салбарын өнөөгийн байдлыг найдвартай гэж үзсэн нь орон нутагт цөөн тооны, найдвартай харилцагч байдагтай холбоотой.

Зураг 4.22 Санхүүгийн зуучлалын үзүүлэлт, чиглэлийн индекс (-1<0 найдвар муутай, 0 эргэлзээтэй, 0<1 найдвартай)



Эх сурвалж: ҮСХ, Монголбанк НЭЭС-ийн түүвэр судалгаа

Зураг 4.23 Банкны салбарын үйл ажиллагаа (Аймгуудаар) (-1<0 найдвар муутай, 0 эргэлзээтэй, 0<1 найдвартай)



Эх сурвалж: Монголбанк НЭЭС-ийн түүвэр судалгаа

2009 оны судалгаагаар чиглэлийн индекс огцом унасан нь эдийн засгийн хямралтай холбоотой бөгөөд харин 2011-2014 оны хооронд иргэдийн банкинд итгэх итгэл эрс нэмэгдэж санхүүгийн зуучлалын үзүүлэлтүүд улам сайжирсан байна. Банкуудын хувьд зээлийн шалгуур, нөхцөлөө чангаруулж улмаар зээл хумигдах хандлагатай болсон нь энэ удаагийн судалгаагаар иргэдийн банкинд итгэх итгэл өмнөх судалгааны дүнгээс бага зэрэг буурахад нөлөөлжээ.

Говьсүмбэр, Увс, Дорнод, Хөвсгөл болон Өвөрхангай аймгуудад иргэдийн банкинд итгэх итгэл өндөр байгаа нь чиглэлийн индексээс харагдаж байна. Харин Өмнөговь, Төв аймаг болон Улаанбаатар хотод иргэд банкны салбарын өнөөгийн байдал бага зэрэг эргэлзээтэй байна гэж үзжээ. Өөрөөр хэдбэл эдгээр аймгуудын иргэдийн хувьд банкинд итгэх итгэл бусад аймгуудын иргэдээс муу байна.

Шигтгээ 9. Санхүүгийн байгууллагуудын ерөнхий мэдээлэл

Банк санхүүгийн байгууллагууд нь эдийн засаг дахь мөнгөн хөрөнгийг үр ашигтай хуваарилах санхүүгийн зуучлалын үүрэг гүйцэтгэх бөгөөд эдийн засгийн өсөлт, хөгжилд чухал нөлөө үзүүлдэг. Хөгжингүй орнуудтай харьцуулахад бага, дунд орлоготой улс орнуудын санхүүгийн систем нь ихэвчлэн банк төвтэй байдаг. Энэ нь тухайн улсын засаглал, институцийн чанар, эдийн засгийн бүтэц, хууль эрх зүйн орчин зэрэг нийтлэг хүчин зүйлстэй холбоотой юм.

Манай улсад 2015 оны эцсийн улирлын байдлаар 14 банк, 450 банк бус санхүүгийн байгууллага (ББСБ), 253 хадгаламж зээлийн байгууллага (ХЗХ), 16 даатгалын компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт санхүүгийн системийн 96 орчим хувийг банкны салбар дангаараа бүрдүүлж байна. Үлдсэн 4-н хувийг банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон даатгалын байгууллагын хөрөнгө бүрдүүлж байна.

№	Нийт хөрөнгийн хэмжээ (тэрбум ₮)	2014	2015
1	Банк	22,562.6	21,556.7
	<i>Банк, санхүүгийн салбарт эзлэх хувь</i>	<i>96.8%</i>	<i>96.1%</i>
2	Банк бус санхүүгийн байгууллага	508.0	623.2
	<i>Банк, санхүүгийн салбарт эзлэх хувь</i>	<i>2.2%</i>	<i>2.8%</i>
3	Хадгаламж зээлийн хоршоо	80.5	97.6
	<i>Банк, санхүүгийн салбарт эзлэх хувь</i>	<i>0.3%</i>	<i>0.4%</i>
4	Даатгалын байгууллага	152.5	147.1
	<i>Банк, санхүүгийн салбарт эзлэх хувь</i>	<i>0.7%</i>	<i>0.7%</i>
5	Нийт хөрөнгө	23,303.6	22,424.6

Эх сурвалж: Монголбанк, СЗХ

Банкны салбар

Банкны салбарт 2015 оны байдлаар нийт 14 банк, 1482 салбар, нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 2.8 сая, зээлдэгчийн тоо 893 мянгад (давхардсан тоогоор) тус тус хүрчээ.

Банкны салбарын нийт актив 2015 оны IV улирлын байдлаар 21.5 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 4.8 хувиар буурчээ. Банкны салбарын актив өмнөх жилээс буурсан нь нийт зээл олголт саарсан нь голлох нөлөөг үзүүлжээ.

Нийт зээлийн өрийн үлдэгдэл 11.3 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 7.4 хувиар буурсан дүнтэй гарчээ. Үүнд эдийн засгийн өсөлт удааширсан, чанаргүй зээлийн хэмжээ өссөн зэргээс үүдэн зээл хумих бодлого баримталж байгаа нь гол нөлөөг үзүүлж байна.

№	Үндсэн үзүүлэлтүүд	2014	2015
1	Банкны тоо	14	14
2	Салбар нэгжийн тоо	1,486	1,482
3	Ажилтнуудын тоо	15,227	15,422
4	Харилцагчдын тоо	8,360,071	8,934,905
5	Хадгаламж эзэмшигчдийн тоо (давхардсан тоогоор)	2,713,330	2,833,540
6	Зээлдэгчийн тоо	803,060	893,030
7	Нийт актив (тэрбум ₮)	22,562.6	21,556.7
	Банк, санхүүгийн салбарт эзлэх хувь	96.8%	96.1%
8	Зээлийн өрийн үлдэгдэл (тэрбум ₮)	12,116.8	11,633.6
	Банк, санхүүгийн салбарт эзлэх хувь	96.9%	97.5%
9	Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (төгрөг)	12.5%	13.3%
10	Тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү /төгрөг/	19.5%	19.1%

Эх сурвалж: Монголбанк

Банк бус санхүүгийн байгууллага

2015 оны IV улирлын байдлаар нийт 450 ББСБайгууллага санхүүгийн зохицуулах хорооноос (СЗХ) олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна.



Эх сурвалж: СЗХ

Сүүлийн жилүүдэд ББСБ-н тоо ихээхэн өсөх хандлагатай байгаа бөгөөд өнгөрсөн хоёр жилийн хугацаанд ББСБ-н тоо хоёр дахин нэмэгджээ.

№	Үндсэн үзүүлэлтүүд	2014	2015
1	ББСБ-ын тоо	378	450
2	Хувьцаа эзэмшигчдийн тоо	868	922
3	Ажиллагсдын тоо	1,678	1,995
4	Салбар нэгжийн тоо	92	116
5	Харилцагчдын тоо	663,098	636,341
6	Нийт актив /тэрбум ₮/	508	623.2
	Банк, санхүүгийн салбарт эзлэх хувь	2.25%	3.01%
7	Зээлийн өрийн үлдэгдэл /тэрбум ₮/	332	424.2
	Банк, санхүүгийн салбарт эзлэх хувь	2.7%	3.6%

Эх сурвалж: СЗХ

Хадгаламж, зээлийн хоршоо

2015 оны байдлаар 253 Хадгаламж, зээлийн хоршоо СЗХорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Хадгаламж, зээлийн хоршоодын активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.3 хувиар буюу 17.1 тэрбум төгрөгөөр өсч 97.6 тэрбум төгрөгт хүрэв.

№	Үндсэн үзүүлэлтүүд	2014	2015
1	ХЗХ-ын тоо	159	253
2	Гишүүдийн тоо	30,698	39,146
3	Нийт актив (тэрбум ₮)	80.5	97.6
	Банк, санхүүгийн салбарт эзлэх хувь	0.3%	0.4%
4	Зээлийн өрийн үлдэгдэл (тэрбум ₮)	61.5	75.3
	Банк, санхүүгийн салбарт эзлэх хувь	0.5%	0.6%

Эх сурвалж: СЗХ

Даатгалын байгууллага

2015 улирлын байдлаар даатгалын зах зээл дээр 15 ердийн болон 1 урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг компани, 3340 даатгалын төлөөлөгч, 37 даатгалын зуучлагч компани, 27 даатгалын хохирол үнэлэгч компани, 15 актуарч, нийт 3691 тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчид үйл ажиллагаа явуулж байна.

№	Үндсэн үзүүлэлтүүд	2014	2015
1	Даатгагч	17	16
2	Даатгалын төлөөлөгч	3,260	3,340
3	Даатгалын зуучлагч	30	37
4	Даатгалын хохирол үнэлэгч	20	27
5	Актуарч	15	15
6	Нийт хөрөнгийн хэмжээ /тэрбум ₮/	152.5	147.1
	Банк, санхүүгийн салбарт эзлэх хувь	0.7%	0.7%

Эх сурвалж: СЗХ

4.6. Хадгаламж, зээл

Судалгаанд оролцсон иргэдийн тал орчим буюу 53% нь мөнгөн хуримтлал байхгүй гэсэн бол хуримтлалтай иргэдийн дийлэнх нь банкинд хадгалуулдаг гэжээ.

Зураг 4.24 Хуримтлуулсан мөнгөө юунд зарцуулдаг вэ?




Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Худалдаа хийж эргэлдүүлдэг, бусад зээлдүүлдэг, үл хөдлөх хөрөнгө худалдан авдаг гэсэн хариултын хувь өмнөх судалгааны дүнгээс бага зэрэг буурсан байна.

Мөнгөн хуримтлалгүй иргэдийн тоо буурч банкны салбарын хадгаламжийн өсөлт саарч байгаа нь иргэдийн орлогын бууралттай холбоотой байж болох юм. Судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх буюу 70% нь мөнгөө төгрөгөөр хадгалахыг илүүд үздэг гэсэн бол 24% нь ам.доллараар хадгалахыг илүүд үзжээ.

Зураг 4.25 Мөнгөө ямар валютаар хадгалахыг илүүд үзэж байна вэ?




Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Иргэдийн дийлэнх нь хадгаламжаа төгрөгөөр байршуулах сонирхолтой байна гэсэн ч өмнөх судалгааны дүнтэй (2015 оны судалгааны үр дүн 75%) харьцуулахад буурсан үзүүлэлт бөгөөд ам.доллаар хадгалуулна гэсэн хариулт бага зэрэг (өмнөх судалгааны дүнгээс 6 нэгж %) өсчээ. Хэдийгээр иргэдийн төгрөгт итгэх итгэл төдийлөн буураагүй ч төгрөгийн ханшийн сулралттай холбоотойгоор цөөнгүй иргэд мөнгөө ам.доллаар хадгалахыг илүүд үзэж байгаа нь төгрөг, валютын хадгаламжийн харьцааны бууралтаас харагдаж байна (шигтгээ 10).

Шигтгээ 10. Хадгаламж, зээл


Нийт хадгаламж

Нийт хадгаламжийн хэмжээ 2016 оны 4 дүгээр сарын байдлаар 6.7 их наяд төгрөгт хүрсэн байна. Хадгаламжийн өсөлтийг авч үзвэл 2015 онд дунджаар 13.3% хүрч байсан бол 2016 онд өсөлтийн хурд саарч дунджаар 9.6%-тай байна.



Эх сурвалж: Монголбанк


Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2016 оны 4 дүгээр сарын байдлаар 2,011 төгрөгт (сарын дундаж ханш) хүрсэн байна. Төгрөгийн ханш 2015 онд дунджаар 8.4%-иар суларсан бол 2016 оны эхний 4 сарын байдлаар дунджаар 2.9%-иар суларчээ.



Эх сурвалж: Монголбанк

Банк, ББСБ-ын зээлжүүлэлт

Хадгаламжийн байгууллагын нийт зээлийн өрийн үлдэгдэл 2016 оны 4 дүгээр сарын байдлаар 11.6 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүний 96 орчим хувийг банкны салбарын зээл дангаараа бүрдүүлж байна.




Эх сурвалж: Монголбанк, СЗХ

Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн өрийн үлдэгдэл 2016 оны 4 дүгээр сарын байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 26.2%-иар өсч 520.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Зээлийн хүү

2016 оны I улирлын байдлаар олгосон зээлийн (төгрөгийн) жигнэсэн дундаж хүү оны эхнээс 0.7 нэгж хувиар нэмэгдэж 19.7%-д хүрсэн байна.



**Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн зээл оруулснаар*


Эх сурвалж: Монголбанк

Харин олгосон зээлд үнэ тогтворжуулах хөтөлбөрийн зээлийг оруулж тооцвол зээлийн жигнэсэн дундаж хүү 17.9%-тай байна.

Орон нутаг дахь банкуудын олгож буй зээлийн хүү 2016 оны I улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар буурч 18.3 хувь буюу улсын жигнэсэн дундаж хүүнээс 1.4 нэгж хувиар доогуур байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 68% нь зээлийн хүү өндөр, 32% нь боломжийн байна гэжээ.


Зураг 4.26 Зээлийн хүү ямар байна вэ?



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Банкны салбарын зээлийн хүүг өндөр байна гэж үзсэн хариултын хувь Улаанбаатар хот болон орон нутагт ойролцоо түвшинд байна.


Зураг 4.27 Зээлийн хүүний чиглэлийн индекс (-1-ээс 0 боломжийн, 0-ээс 1-д өндөр)



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Энэ удаагийн судалгаагаар зээлийн хүүний чиглэлийн индекс өмнөх судалгааны дүнгээс бага зэрэг буурсан хэдий ч “зээлийн хүү өндөр” гэсэн мужид хэвээр байна. Үүнд Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг, шинэ суурьшлын бүсэд баригдсан орон сууцны ипотекийн 5 хувийн зээл, “Сайн малчин” хөтөлбөрийн 10%-ийн зээл зэрэг бага хүүтэй зээлүүдийг 2016 он гарснаас хойш олгож эхэлсэн нь нөлөөлсөн байх талтай.

Зураг 4.28 Зээлийн хүүний чиглэлийн индекс (Аймгуудаар)
(-1-ээс 0 боломжийн, 0-ээс 1-д өндөр)



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Чиглэлийн индексээс харахад Дорноговь, Говьсүмбэр, Говь-Алтай болон Дархан-Уул аймагт зээлийн хүү бусад аймгуудтай харьцуулахад бага байгаа бол Дундговь, Өмнөговь, Булган зэрэг аймгуудад зээлийн хүү өндөр байна. Мөн нийт аймгуудын хувьд зээлийн хүүний зөрүү харьцангуй бага байгаа нь ажиглагдаж байна.

Зураг 4.29 Зээл авахад ямар бэрхшээл тулгарч байна вэ?



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Санал асуулгад оролцсон иргэдийн хамгийн их буюу 31% нь зээлийн хүү өндөр байгаа нь зээл авахад гол хүндрэл болдог гэж хариулсан байна. Үүний дараагаар иргэдийн 12% нь зээлийн барьцаа хөрөнгө байхгүй, 10% нь зээлийн шимтгэл хураамж өндөр, 10% нь барьцаа хөрөнгийн үнэлгээ доогуур гэсэн бол 10% нь зээлийн хугацаа богино байгаагаас шалтгаалж зээл авахад хүндрэл тулгарч байна гэжээ.


Иргэдийн хувьд зээлийн хүү өндөр гэсэн ерөнхий хандлага буурсан ч зээл авахад хамгийн их бэрхшээл болсон хэвээр байгаа нь судалгаагаар харагдаж байна.

4.7. Ипотекийн зээл

Судалгаанд хамрагдсан иргэдийн 20% нь ипотекийн зээлийн хөтөлбөрт хамрагдсан бол үлдсэн 80% нь хамрагдаагүй гэж хариулжээ.

Монгол улсын хэмжээнд 2015 оны эцсийн байдлаар нийт 859 мянган өрх байгаагийн 10 орчим хувь нь орон сууцны ипотекийн зээлд хамрагдсан бол түүвэр судалгаанд оролцогчдийн 20 орчим хувь нь ипотекийн зээлд хамрагджээ. Энэ нь уг судалгаанд ипотекийн зээлтэй иргэдийн төлөөлөл түлхүү оролцож санал бодлоо тусгасныг харуулж байна.

Зураг 4.30 Бага хүүтэй (8%, 5%) орон сууцны ипотекийн зээлд хамрагдсан уу?




Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Улаанбаатар хотод ипотекийн зээлд хамрагдаж чадаагүй гэсэн иргэдийн хариултын хувь хөдөө орон нутагтай харьцуулахад бага зэрэг өндөр байна.

Шигтгээ 11. Ипотекийн зээлийн мэдээ

Банкууд 2016 оны I улирлын байдлаар 81,015 иргэдэд нийт 3,565.3 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг олгосон байна.



Эх сурвалж: Монголбанк

2016 оны 3 дугаар сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд өмнөх сартай харьцуулахад 3.1 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 18.2 нэгж хувиар тус тус өслөө.



Эх сурвалж: Монголбанк

Тус сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн 75.2 хувь буюу 2679.8 тэрбум төгрөгийг “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл (жилийн 5 болон 8 хувийн хүүтэй зээл, 5 болон 8 хувийн хүүтэй зээлд шилжүүлсэн зээл), 23.1 хувь буюу 822.1 тэрбум төгрөгийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 1.8 хувь буюу 63.4 тэрбум төгрөгийг бусад эх үүсвэрээр олгосон зээл бүрдүүлж байна.

Зээлдэгчдийн тоо

2016 оны 3 дугаар сарын байдлаар нийт 81015 иргэн ипотекийн зээлтэй байгаагаас 57659 нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд (үүнээс 252 нь 5 хувийн хүүтэй зээлд, 540 нь 8 хувиас 5 хувь руу шилжсэн зээлд хамрагджээ), 21432 нь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээлд, 1924 нь бусад эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.




Эх сурвалж: Монголбанк

Орон сууцны үнийн индекс

2016 оны 3 дугаар сарын байдлаар орон сууцны үнийн индекс өмнөх сараас 1.0%-иар, өнгөрсөн оны мөн үеэс 10.9%-иар тус тус буурчээ.

Тухайн сард зах зээлд нийлүүлэгдсэн шинэ болон хуучин орон сууцны үнийн бууралт үргэлжилсэн хэвээр байгаа нь орон сууцны дундаж үнэ буурахад нөлөөлж байна.




Эх сурвалж: “Тэнлэг зууч” ҮХХЗК

2013 оны 1 дүгээр сараас эхлэн орон сууцны үнийн индексийг тооцсон бөгөөд орон сууцны үнийн жилийн өсөлт 2014 оны 3 дугаар сард хамгийн өндөр буюу 23.7%-тай гарсан байна. 2014 оны 12 дугаар сараас орон сууцны үнэ (өмнөх оны мөн үетэй харьцуулахад) буурч эхэлсэн бөгөөд орон сууцны үнийн бууралт үргэлжилсэн хэвээр байна.

Судалгаанд оролцсон ипотекийн зээлтэй иргэдийн хувьд зээлд хамрагдсанаар хэрэглээ нэмэгдсэн гэж 33%, хэвэндээ гэж 37% нь хариулсан бол хэрэглээ буурсан гэж 31% нь хариулжээ.

Зураг 4.31 Ипотекийн зээл авснаар таны хэрэглээнд өөрчлөлт гарсан уу?



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Орон сууцны ипотекийн зээлд хамрагдсан өрхийн хэрэглээг орон сууц ипотекийн зээлд хамрагдаагүй өрхийн хэрэглээний бүтэцтэй харьцууллаа.


Зураг 4.32 Ипотекийн зээлтэй болон зээлгүй иргэдийн хэрэглээний ялгаа



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Ипотекийн зээлтэй өрхийн хувьд хувцас гутал, боловсрол, тээврийн зардал нь зээлгүй өрхийнхөөс харьцангуй бага байдаг байна. Харин ус дулаан, байрны төлбөр (*түрээсийн зардал*), хэрэглээний болон бизнесийн зээлийн төлбөр нь орон сууцны ипотекийн зээлгүй өрхийнхөөс бага зэрэг өндөр байна.

Зураг 4.33 Ипотекийн зээл авснаар таны амьдралд ямар нөлөө үзүүлсэн бэ?




Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Түүнчлэн ипотекийн зээлтэй иргэдийн хувьд амьдралд нь эерэг өөрчлөлтүүд гарсан гэж үзэж байна.

Харин ипотекийн зээлд хараахан хамрагдаж чадаагүй байгаа иргэдийн хувьд урьдчилгаа буюу барьцаа байхгүй, орлогын түвшин хүрэхгүй байгаа нь ипотекийн зээлд хамрагдахад ихээхэн бэрхшээл болж байна.

Зураг 4.34 Ипотекийн зээлийн хөтөлбөрт хамрагдахад ямар бэрхшээл тулгарч байна вэ?



Эх сурвалж: Монголбанк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Түүнчлэн зах зээлд нийлүүлэгдсэн шинэ болон хуучин орон сууцны үнэ буурч байгаа нь орон сууцны дундаж үнэ буурахад нөлөөлж байгаа хэдий ч сүүлийн жилүүдэд өрхийн орлого дорвитой нэмэгдээгүй нь орон сууц худалдан авахад гол хүндрэл болж байна.

4.8. Нийгэм, эдийн засгийн байдлын талаарх түүвэр судалгааны дүгнэлт

Эдийн засгийн гадаад орчны таагүй байдал үргэлжилсэн хэвээр, эдийн засгийн салбаруудын тэр дундаа барилга, худалдаа, үйлчилгээний салбаруудын идэвхжил суларч, өсөлт саарахад голлон нөлөөлж байна. Түүвэр судалгааны үр дүнгээр иргэдийн эдийн засгийн өнөөгийн байдалд өгсөн үнэлгээ өмнөх оноос бага зэрэг сайжирсан ч эдийн засгийн ерөнхий байдал муу хэвээр байна гэж хариулжээ.

Инфляцийн түвшин буурч байгаа өнөөгийн нөхцөлд иргэдийн дунд үнийн өсөлтийн түвшин нэмэгдэж байна гэж үзэх хандлага буурч, 2009 оны хямралын үеийнхтэй ойролцоо түвшинд гарлаа.

Эдийн засгийн идэвхжил суларч, бизнесийн үйл ажиллагаа хумигдсанаар ажилгүйдэл огцом нэмэгдэж, өрхийн төсөв, санхүүгийн байдал муудсан нь иргэдийн дунд ажилгүйдэл, ядуурал нэмэгдсэн гэх хандлага өсөхөд нөлөөлсөн байна.

Иргэдийн дунд уул уурхайн салбарт итгэх итгэл хэвээр байгаа ч эдийн засгийн хөгжлийг дэмжих, төрөлжүүлэх, урт хугацааны тогтвортой байдлыг хангахын тулд нэн тэргүүнд ЖДҮ-н хөгжлийг дэмжих, боловсруулах үйлвэрүүдийг байгуулах, ХАА-н үйлдвэрлэл, экспортыг дэмжих нь зүйтэй гэж үзсэн байна. Түүнчлэн судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх нь гадаадаас зээл авах нь эдийн засгийн өнөөгийн байдалд дэмжлэг үзүүлэхгүй бөгөөд урт хугацаанд өрийн дарамтад оруулах эрсдэлтэй гэжээ.

Банкуудын зээлийн нөхцөл, шалгуур чангарсантай холбоотойгоор судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь мөнгөний хэрэгцээ гарсан үед хувь хүн, ломбард болон банкнаас бусад санхүүгийн байгууллагад хандаж байна. Энэ удаагийн судалгааны дүнгээр иргэдийн банкинд итгэх итгэл өмнөх судалгааны дүнгээс бага зэрэг буурсан байна. Нийт хадгаламжийн өсөлт саарсан, зээл олголт буурсан, чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж байгаа нь иргэдийн банкинд итгэх илтгэл буурахад нөлөөлсөн байх талтай.

Санал асуулгад оролцсон иргэдийн хамгийн их буюу 31% нь зээлийн хүү өндөр байгаа нь зээл авахад гол хүндрэл болж байна гэж үзжээ. Банкуудын зээлийн нөхцөл чангарч, зээлийн жигнэсэн дундаж хүү өсөх хандлагатай байгаа нь иргэд зээл авахад зээлийн хүү гол хүндрэл болж байна гэж үзэхэд нөлөөлжээ. Судалгаанд оролцсон иргэдийн талаас илүү хувь нь мөнгөн хуримтлал байхгүй (*өмнөх судалгааны дүнгээс 7 нэгж хувиар өссөн*) гэсэн бол хуримтлалтай иргэдийн ихэнх нь банкинд хадгалуулдаг (*өмнөх судалгааны дүнгээс 3 нэгж хувиар буурсан*) гэжээ.

Орон сууцны ипотекийн зээлтэй өрхийн хувьд зайлшгүй бус хэрэглээний (*хувцас гутал, боловсрол, тээвэр*) зардал нь зээлгүй өрхийнхөөс харьцангуй бага байгаа бол зайлшгүй хэрэглээний (*ус, дулаан, байрны төлбөр*) зардал болон хэрэглээ, бизнесийн зээлийн төлбөр нь орон сууцны ипотекийн зээлгүй өрхийнхөөс бага зэрэг өндөр байдаг байна. Энэ нь иргэд ипотекийн зээлд хамрагдсанаар зайлшгүй

бус хэрэглээний зардлаа тодорхой хэмжээгээр хумих, хандлагатай болсныг харуулж байна.

Харин ипотекийн зээлд хамрагдаж чадаагүй иргэдийн хувьд урьдчилгаа буюу барьцаа хөрөнгө байхгүй, орлогын түвшин хүрэлцэхгүй, орон сууцны үнэ хэт өндөр зэргээс шалтгаалж орон сууц худалдан авч чадахгүй байна.

V. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Эдийн засгийн гадаад орчны таагүй байдал үргэлжилж, уул уурхайн салбарын зогсонги байдал хэвээр байгаа нь эдийн засгийн бусад салбарууд болон нийт эдийн засагт сөргөөр нөлөөлж байна.

Эдийн засгийн өсөлт тэр дундаа барилга, худалдаа, үйлчилгээний салбаруудын идэвхжил суларч, иргэдийн бодит орлого төдийлөн өсөөгүйн зэрэгцээ ажилгүйдэл нэмэгдсэн нь өрхийн амьжиргаа доошлоход нөлөөлж, улмаар иргэдийн дунд ядуурал нэмэгдсэн гэх хандлагыг өсгөсөн байна.

Инфляцийн түвшин буурч байгаа өнөөгийн нөхцөлд иргэдийн дунд үнийн өсөлтийн түвшин нэмэгдэж байна гэж үзэх хандлага өмнөх судалгааны дүнгээс буурч гарлаа.

Судалгаанд оролцсон иргэдийн талаас илүү хувь нь мөнгөн хуримтлал байхгүй бөгөөд эдгээр иргэд орлогоос давсан зардлаа ихэвчлэн зээлээр тэр дундаа банкнаас хэрэглээний зээл авч санхүүжүүлдэг байна. Авсан зээлээ эргүүлэн төлөхөд зээлийн хүү өндөр, хугацаа богино байгаагаас гадна ажилгүйдэл нэмэгдэж байгаатай холбоотойгоор өрхийн аль нэг гишүүн ажилгүй болох эрсдэл өндөр байна.

Бизнесийн эрсдэл, чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж байгаа зэргээс шалтгаалж банкууд зээлийн нөхцөл, шалгуураа чангаруулсан. Үүнтэй холбоотойгоор судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь мөнгөний хэрэгцээ гарсан үед хувь хүн, ломбард болон банкнаас бусад санхүүгийн байгууллагад хандах болжээ.